

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 01 сарын 25 -ны өдөр

Дугаар 18/01

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт эхлэв.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын агуулгыг танилцуулж, хурлын ирцийн талаарх мэдээг танилцуулах Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийг индэрт урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийн танилцуулснаар:

Тооллогын комиссын шийдвэр: “1,009,488,025 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй буюу 227 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрхтэй хувьцаа бүхий 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны 94,97 хувийг төлөөлсөн хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн” байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг, ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун нарыг тайзнаа урилаа.

Хурал даргалагч Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга хэлэлцэх асуудлыг танилцуулах
 - I. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;
 - II. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох;
 - III. АПУ ХК-ийн охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгохыг зөвшөөрөх

IV. АПУ ХК-ийн нэгдэлд хамаарагдаж байгаа компаниудын “Эрх мэдлийн хуваарилалт”-ын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлах эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох;

2. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт /хүн тус бүр 3 мин/
3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах /5 мин/
4. Санал хураалт явуулах /20 мин/
5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /40 мин/
6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах /5 мин/
7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /5 мин/
8. Хурлыг хаах

Хэлэлцсэн нь:

1. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд АПУ компанийн хувьцааны 25%-ийг эзэмших хувьцаа эзэмшигч болсон бөгөөд төлөөллөө ТУЗ-д оруулах санал оруулсан болно. Кумулятив аргаар сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох, дахин сонгох Компанийн тухай хуулийн 77-р зүйлд заасан зохицуулалт үйлчилдэг. Иймд уг шаардлагаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох болсон тул ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнөх бүрэн эрхийг дуусгавар болгож шийдвэрлэх шаардлагатай болсон.

Хэлэлцсэн нь:

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн 9 гишүүн (кумулятив аргаар сонгогдох)-ийг сонгох;

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Нэр дэвшигчдийг танилцуулав. ТУЗ-ийн ердийн гишүүнд П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, Г.Ганболд, С.Б.Громов, Кеннет Чу, Яспер Хамакер, хараат бус гишүүнд Ж.Үнэнбат, Ё.Гэрэлчулуун, Ө.Батбаяр, С.Сайнбат нар нэр дэвшив.

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн дагуу кумулятив аргаар хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох журамтай. Кумулятив аргыг хэрэглэх зааврыг танилцуулав.

Хэлэлцсэн нь:

- 3. АПУ ХК-ийн охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох**

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Олон улсын компаниудын туршлагаар охин болон хараат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компанийн ТУЗ хэрэгжүүлдэг; Охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компаниудын удирдлагын бүрэн эрхийг нэгдмэл байдлаар, үр дүнтэй хэрэгжүүлэх; Шийдвэр гаргалтын стандарт бүтцэд шилжих гэсэн зорилго, үндэслэлээр уг асуудлыг оруулж байна.

Хэлэлцсэн нь:

- 4. АПУ ХК-ийн нэгдэлд хамаарагдаж байгаа компаниудын “Эрх мэдлийн хуваарилалт”-ын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлах эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох;**

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ ХК-ийн нэгдэлд хамаарч буй 12 хуулийн этгээдийн үйл ажиллагааг нэгтгэн оновчтой зохион байгуулах практик хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Иймд Хувьцаа эзэмшигчдийг хурлын чөлөө цагт төлөөлөх ТУЗ-д эрх олгож, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхийг даалгаж, “Эрх мэдлийн хуваарилалт”-ын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, бизнесийн соёлд нийцүүлэн боловсруулах, батлахыг ТУЗ-д үүрэг болгох нь зүйтэй байна.

Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичгийн агуулга нь нэгдлийн оролцогч компаниудын удирдлагын бүрэн эрхийн хэмжээ, хязгаарыг тогтооно. Үүнд, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал; Толгой компанийн Гүйцэтгэх удирдлага; Охин болон хараат компанийн Гүйцэтгэх удирдлага; Гүйцэтгэх удирдлагын шууд харъяанд ажиллах Чиг үүрэг хариуцсан захирлуудын эрх хэмжээ, шийдвэр гаргалтын процессыг тусгасан байна.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Бат-оргил: Надад 2 асуулт байна.

1. Нэгдэл амжилттай хийгдлээ. Одоо өрсөлдөөний хувьд ямар бодлого барьж байгаа вэ?
2. Экспортын талаарх баримталж буй чиглэлээ танилцуулна уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. Дотоод өрсөлдөөнийг хадгална. Гол гол бодлогууд нэг явна. Нэгдсэнээр бид зах зээлд давамгайл байдлаар аж ахуй нэгжид хамаарч байгаа тул бодлого,

зарчмаа тодорхойлох ажил хийгдэж байгаа. Зах зээл дээр 20 орчим хувь нь бусад өрсөлдөгчид байгаа болно.

2. Экспортын хувьд бидний нэгдлийн зорилго болж байгаа тул экспортыг нэмэгдүүлэх, гадагшаа зах зээлд гарч тоглогч болоход анхаарлаа хандуулна. Энэ тухай бид 2017.08.18-ны Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байсан төсөөллөө хэрэгжүүлэхээр ажиллана. Үүнд бид Хайнекений сүлжээг ашиглаж хэрэгжүүлнэ.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Отгондорж: Энэ жилийн нийт борлуулалтын төлөвлөгөөгөө танилцуулна уу? Ойрын 3 жилдээ хэрхэн төлөвлөж байна вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Энэ жилийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах ТУЗ-ийн хурал болоогүй байна. Өнөөдөр ТУЗ-ийн гишүүд шинээр сонгогдоно. Шинээр сонгогдсон ТУЗ хурлаа товлож, шинэ шаардлагаар бид ажиллах болно. Мөн бизнес төлөвлөгөө компаниудын хувьд нэгтгэгдэхээр байгаа болно. Одоогоор бизнес төлөвлөгөө батлагдаагүй байгаа учраас хараахан баталгаатай тоо хэлэх боломжгүй байна. Гэхдээ тойм тоо хэлэхэд борлуулалтыг 5%-иар өсгөхөөр ажиллана. Архины хувьд экспортын борлуулалтыг 20%-д хүргэхээр төлөвлөж байна.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Самбуу: Кумулятив арга гэж юуг хэлдэг вэ? Үүнийг орчуулах боломжгүй юу?

Хариулт:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун: Кумулятив арга гэдэг нь санал цуглуулах арга гэж орчуулагдана. Энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зорилго бүхий арга ба том хувьцаа эзэмшигч, хяналтын багц эзэмшигчдийн саналаар бүхий л асуудлыг шийдвэрлэхээс сэргийлсэн арга юм. Тухайлбал том хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн бүхий л гишүүдийг сонгох боломжийг хязгаарлаж, жижиг хувьцаа эзэмшигчид өөрийн бүхий л саналын эрхийн тоогоо нэг ТУЗ-ийн гишүүнд өгөх боломжийг нээж төлөөллөө ТУЗ-д оруулах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Батжаргал: АПУ ХК нь АПУ Трейдинг ХХК-ийн хувьцаа эзэмшигч болж нэг санаа зорилготой компаниуд болсон нь сайн байна. Надад 2 асуулт байна.

1. Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдээ нэгтгэх үү?
2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид өөрсдийгөө танилцуулж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах яаж ажиллах, яагаад нэр дэвших болсноо танилцуулж болох уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ ХК-д түүхий эд туслах материал нийлүүлж буй ханган нийлүүлэгчдээ бид нэгтгэх төлөвлөгөө байхгүй. Харин дэмжих, сонгон шалгаруулалтаа зөв оновчтой болгох, тогтвортой урт хугацааны гэрээтэй, үнийн хувьд жилийн гэрээнийхээ хүрээнд тогтмол ажиллах чиглэлийг баримтална.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун, Ө.Батбаяр нар биечлэн хуралд оролцож байна. Ж.Үнэнбат болон С.Сайнбат нар гадаадад томилолттой байгаа тул оролцоогүй. Одоо нэр дэвшиж буй гишүүд өөрсдийгөө танилцуулна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун: Би 2017 онд ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. Би үйлдвэрийн эдийн засагч мэргэжилтэй. 1990 хойш өмч хувьчлал, хөрөнгийн бирж үүсгэн байгуулагдахад биечлэн оролцож байсан мэргэжлийн хүн ба төрийн ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш ажиллахаар нэр дэвшсэн юм. ТУЗ-ийн хараат бус гишүүний нэмэлт үүрэг бол хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг явуулж буй эсэхэд хяналт тавих, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, компанийн засаглалыг сайжруулах оролцоогоор хувь нэмэр оруулах гэж ойлгодог. Өнгөрсөн 9 сарын хугацаанд Нэгтгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан. Үүнийг дүгнэн хэлэхэд хууль зүйн дагуу, дэлхийн стандартын дагуу, ил тод нээлттэйгээр нэгтгэлийг хийсэн.

ТУЗ-ийн хараат гишүүн Ө.Батбаяр: 2017 оны 6 сараас ТУЗ-ийн хараат гишүүнээр ажиллаж байгаа байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний нэмэлт үүрэг бол аливаа этгээдээс үл хамааралтайгаар хараат бусаар асуудлыг шийдвэрлэх гэж ойлгодог. ТУЗ-ийн гишүүд сонгогдох аргаасаа эхлэн кумулятив аргаар сонгогдож, хувьцаа эзэмшигчдийн том, жижиг гэлтгүй саналыг цуглуулж сонгогддог онцлогтой. Иймд хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, компанийн эрх ашиг, Монгол Улсын хууль тогтоомж зэргийг үндэслэл болгож асуудалд хандаж шийдвэрлэж байдаг. Миний бие ТУЗ-ийн хараат бус гишүүнээр хариуцлагатай ажиллахыг хичээх болно.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ариунжаргал: Жижиг хувьцаа эзэмшигчид нь 6% байдаг. Энэ хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Гадаадын хөрөнгийн биржид хувьцаа гаргах асуудал яригдаж байгаа. Гэхдээ хугацаа болон бусад эдийн засгийн үндэслэл хараахан тодорхой болоогүй байгаа. Үүнд улс төрийн, татварын, бусад салбарын эрх зүйн зохицуулалт чухал нөлөө үзүүлнэ. Нөгөө талаас бид хувьцаагаа 2 удаа хуваасан ба энэ нь хувьцаа арилжааг нэмэгдүүлэхэд чиглэж байсан.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: АПУ ХК нь хөрөнгийн биржийн 1-р ангилалд хамаардаг компани ба түүнд тавигдах шалгуур нь 15% нь олон нийтэд арилжаалагддаг байх, эсвэл хувьцаа арилжааны хэмжээ тодорхой дүнд хүрсэн, давсан байх шаардлага тавигддаг ба манай компанийн хувьцааны арилжааны идэвх биржийн арилжааны хамгийн их хувийг эзэлж, идэвх өндөртэй компанид

ордог бөгөөд биржийн шаардлагыг хангаж байна. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хувьцааны төвлөрлийн тал дээр ямар бодолтой байдгийг би төлөөлж хэлж мэдэхгүй байна. IPO-ийн тухайд нэмж хэлэхэд Монгол Улс нь гадаадын хөрөнгийн биржүүдийн хүлээн зөвшөөрөгдсөн оронд хамаардаггүй бөгөөд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооноос үүн дээр идэвхтэй ажиллаж, гадны биржид Монгол компани шууд гарч бүртгүүлэх боломжийг бүрдүүлснээр хэрэгжихээр боломжтой болно.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ард капитал и/т Раднаадагва: АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг та 3 жилийнх дараах АПУ компани ямар болох талаарх өөрийн төсөөллөө хэлж болох уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Хувь хүний хувьд өөрийн бодлоо хэлэх нь зохимжгүй гэж бодож байна. Гүйцэтгэх захирал бол ТУЗ-өөс томилогддог, хувьцаа эзэмшигчдэд тайлагнадаг, хэдэн мянган ажилчдыг төлөөлдөг хариуцлагатай албан тушаалтан байгаа. 3 жилийн дараа бид боломжийн гайгүй түвшинд хүрсэн байх болно. 2017.08.18-ны хуралд бид 5 жилийн санхүүгийн төсөөллөө танилцуулсан. Давхцаж буй зардлыг хасах, хэмнэх, цэвэр ашгийг өсгөх, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах ба 60 гаруй тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах боломжтой гэж үзсэн.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Солонгоо: Аньс, чацаргана, нэрс зэрэг түүхий эдийг дотоодоос органик бүтээгдэхүүн авч ашиглаж байна уу? Цаашдаа туслах аж ахуй байдлаар зохион байгуулж тарьж ургуулах төлөвлөгөө байгаа юу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компанийн менежментийн бодлого бол дотоодод үйлдвэрлэсэн, бидний стандарт шаардлагыг хангаж буй гэрээлэгчдийг сонгон шалгаруулах явдал байдаг. Гэвч зах зээл дэх өрсөлдөгчдийн хувьд дотоодын төдийгүй гадаадын (импортын) бүтээгдэхүүнүүд байдаг. Тиймээс дэлхийн хэмжээний бүтээгдэхүүнтэй өрсөлдөхийн тулд тийм стандартыг бид тавьдаг ба түүхий эд туслах материалын стандартыг хангаж буй бүх нийлүүлэгчдэд бид нээлттэй байдаг. Таны асуусан аньс, чацаргана, нэрс зэрэг түүхий эдийг бид дотоодоос бүрэн авч ашиглаж байгаа. Компанийн хувьд хөдөө аж ахуйн бизнест орох бус дэмжих, хэрэглэгч нь болох бодлого барьж ажиллаж байна.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ангарагбат: Надад 3 асуулт байна.

1. 2 компанид ижил төрлийн бүтээгдэхүүнүүд (боргио ба жалам хар) байгаа. Тэдгээрийг цаашид үйлдвэрлэх үү? яах вэ?

2. Зах зээлд 65-80%-ийг эзэлж байна. Бүтээгдэхүүнүүдийнхээ үнийг нэмэх үү? Ашгийг өсгөх үү?
3. АПУ Трейдинг ХХК-иар дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулах үйл ажиллагаанд өөрчлөлт орох уу? Борлуулах үнэ, ашгийг аль компанид ашигтай байхаар зохицуулах вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. 2 компанийн хоорондын өрсөлдөөнийг хадгалах бодлого барьж байгаа. Гэхдээ энэ процесст маш их синержи үүсэх боломжтой. Үүн дээр гадны компанийн туслалцаатайгаар портфойлоо менежментийн судалгаа хийгдэхээр яригдаж байна. Улмаар алийг хөгжүүлэх үү, алийг зах зээлээс татан авах уу, алийг хэвээр хадгалах уу гэдгийг бодлогын баримт батлагдана.
2. Бид сайн дураар үнэ нэмэх, бууруулахад хуулийн зохицуулалт үйлчилж байгаа. Үнэ нэмэх тухайд онцгой албан татварын хувь хэмжээ нэмэгдэх (2018 онд 10%, 2019 онд 5%, 2020 онд 5% тус тус нэмэгдэнэ), валютын ханш нэмэгдэх зэргээс шууд шалтгаалж үнэ өснө. Нэгжид ногдох өртгөө бууруулж ашгаа хэрхэн өсгөх талаар ажиллана.
3. Одоо АПУ Трейдинг ХХК нь 100% АПУ ХК-ийн охин компани. Хуучин бол хүмүүсийн дунд ашгаа шилжүүлж байна гэсэн хар явж байсныг үгүйсгэхгүй ба бидний хооронд үнэндээ бусдын харддаг шиг бага хэмжээний ашиг нэмж борлуулдаггүй ба АПУ ХК-д илүү ашигтай байдаг байсан. Өнгөрсөн онд АПУ Трейдинг ХХК алдагдалтай ажилласан ба борлуулалт гэхээсээ илүү ложистикийн маш том хэмжээний зардал гардаг компани юм. Одоогоор компаниудын Гүйцэтгэх захирал нэг болсон бөгөөд цаашид харилцаа хуулийн дагуу явна. Ашгийг аль компани дээр байлгах уу гэдгийг ч хуулийн дагуу шийдвэрлэгдэх ёстой. Иймд хуулийн дагуу ашгийг толгой компани дээр хэрхэн байлгах вэ гэдэг бодлого барих байх гэж бодож байна.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Самданпунцаг: АПУ бүтээгдэхүүнээ аль улс руу экспортолж байгаа вэ? Хмель буюу зөрөг цэцгийг хаанаас авдаг вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Одоогоор ОХУ, БНХАУ, Япон, Солонгос зэрэг улс руу экспорт хийж байна. Хмелийг Германаас авдаг.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Сүхбаатар: Хайнекены борлуулалт хаагуур хийгдэх вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Бид дистрибьютор хийж Хайнекен брэндийг зарж байгаа, өөрөөр хэлбэл манай охин компани МВС борлуулж байгаа.

Асуулт, хариултын хэсэг дуусав.

Санал хураалт явагдав.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэг: Санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1,3,4 асуудлаар 1,008,802,119 ширхэг хувьцаа эзэмшиж буй 193 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүчин төгөлдөр байсан бол үлдэх 143,491 ширхэг хувьцаатай 20 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчингүй байна. 2 асуудлаар 1,008,453,614 ширхэг хувьцаа эзэмшиж буй 127 хувьцаа эзэмшигчийн санал хуудас хүчин төгөлдөр үлдэх 491,996 ширхэг хувьцаатай 86 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

1. “АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 1,008,774,876 ширхэг хувьцаа буюу 99,9973%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 24,923 ширхэг хувьцаа буюу 0,0025%,

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 2,320 ширхэг хувьцаа буюу 0,0002%.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох:

а. “АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох” асуудлаар:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Г.Ганболд	1,717,285,756	28,38%
2	П.Батсайхан	869,288,746	14,37%
3	С.Громов	865,652,242	14,31%
4	Яспер Хамакер	865,927,412	14,31%
5	Б.Батбаяр	865,370,293	14,30%
6	Кеннет Чу	863,934,486	14,28%
7	П.Батчимэг	3,262,749	0,05%

б. “АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох” асуудлаар:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Ж.Үнэнбат	1,008,548,388	33,34%
2	Ё.Гэрэлчулуун	1,008,357,565	33,33%
3	Ө.Батбаяр	1,007,972,803	33,32%
4	С.Сайнбат	446,086	0,01%

3. “АПУ ХК-ийн охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 1,008,791,556 ширхэг хувьцаа буюу 99,9990%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 6,228 ширхэг хувьцаа буюу 0,0006%,

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 4,335 ширхэг хувьцаа буюу 0,0004%.

4. АПУ ХК-ийн нэгдэлд хамаарагдаж байгаа компаниудын “Эрх мэдлийн хуваарилалт”-ын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлах эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгох

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 1,008,798,085 ширхэг хувьцаа буюу 99,9996%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 1,919 ширхэг хувьцаа буюу 0,0002%,

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 2,115 ширхэг хувьцаа буюу 0,0002%,

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2017 онд сонгогдсон ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдээс дараах хүмүүсийг сонгов. Үүнд:
 - 1) П.Батсайхан
 - 2) Б.Батбаяр
 - 3) С.Б.Громов
 - 4) Г.Ганболд
 - 5) Кеннет Чу
 - 6) Яспер Хамакер
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс дараах хүмүүсийг сонгов. Үүнд:
 - 1) Ж.Үнэнбат
 - 2) Ё.Гэрэлчулуун
 - 3) Ө.Батбаяр


4. “АПУ ХК-ийн охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгохыг зөвшөөрөв.
5. АПУ ХК-ийн нэгдэлд хамаарагдаж байгаа компаниудын “Эрх мэдлийн хуваарилалт”-ын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлах эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгохыг зөвшөөрөв.

Ээлжит бус хурлыг хаав.

Хурал 14 цаг 58 минутад дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан